



“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

17120 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Буянт-Ухаа 45
Утас: 70049919, 70049973
www.miat.com

2024.09.02 № 03/2254

танай _____ -ны _____ №-т

Хариу хүргүүлэх тухай

Танай 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 01/1498 тоот албан бичигтэй танилцлаа.

МИАТ/20240103122 дугаартай “Агаарын хөлгийн иж бүрэн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдол болон тендерийн баримт бичгийг хянасан тухай албан тоотын дагуу “Захиргааны ерөнхий хууль”-ийн 98 дугаар зүйлийн 98.2-т заасныг үндэслэн тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1-т “Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”,... а) Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх/ IELTS-ийн 6 ба түүнээс дээш, TOEFL IBT- 60 ба түүнээс дээш оноо авсан байх эсвэл Англи хэлээр гадаад улсад сургууль төгсөн бакалавр эсвэл магистрын диплом авсан байх, дипломын хуулбар, сертификатыг ТББ-д хавсарган ирүүлэх/” гэж заасныг “Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй байх /Сертификатыг ТББ-д хавсарган ирүүлэх/ болгон өөрчилсөн.

Иймд цахим системд нийтэлсэн тендерийн баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулан тендер түдгэлзсэн хугацаагаар тендерийн нээлт хийх хугацааг сунган тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулах болсныг хариу мэдэгдэж байна.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАХИРГАА
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ



Э.МӨНХМАРАЛ

0000004399